



ДОРНОГОВЬ АЙМАГ  
АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 0/21

Цагаандөрвөлж

Газар эзэмшүүлэх төсөл сонгон  
шалгаруулалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам”, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07/35 дугаар “Газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 3 нэгж талбарыг малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацааг хавсралтаар баталсугай.

2.Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2026 оны 05 дугаар сарын 29-ны өдөр холбогдох хууль тогтоомжийн дагуу танхимын хэлбэрээр зохион байгуулахыг сумын газрын даамал (Т.Золбоо)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын тамгын газрын дарга (Л.Туул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНБААТАР

Айраг сумын Засаг даргын 2026  
оны 05 дугаар сарын 14 -ны өдрийн  
А/74 дугаар захирамжийн хавсралт



ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН  
БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ХУГАЦАА

№	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Эзэмшүүлэх газрын байршил	Хэмжээ м.кв	Зориулалт	Эзэмшүүлэх хугацаа
1	5025015	Муу усны урд	50000	1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл	15 жил
2	5025016	Ар говь /гүүр/	50000	1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл	15 жил
3	5025028	Бойны цэгээс хойш	50000	1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл	15 жил

----0-0-0----